**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэ сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/003/НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор:Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер:Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор:Д.Цэрэнханд<br>Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn<br>Аудитор: Г.Энхдэлгэр<br>Утас: 99002291 Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт
Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
Гурав. Аудитын илрүүлэлт
Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 08. 25 № 149

танай ____________ -ны № ______________ -т

ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.НЯМДАВАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй. Үүнд:

- Малын тоо толгойн албан татвар 38.2 сая төгрөгөөр, шууд бус орлого 21.5 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 1.2 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.3 сая төгрөгөөр тус тус тасарсан,
- Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2.2 сая төгрөгийг бэлэг дурсгал, шагналд зарцуулсан,
- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 96.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

822511000439

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалт, "Сумын 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 729.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 747.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 102.5 хувиар биелүүлжээ.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,109.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн олгосон байна.

**Аудитын гол асуудал**

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байхад бэлэг дурсгал, шагналд төсөв зарцуулсан.

Тайлант онд Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв нь тогтмол зардлын 63.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 9 зорилт, 83 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 96.2 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 735,499.4 | 988,794.5 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 265,413.3 | 489,852.1 |
| 3 | АВЛАГА | 106,306.1 | 138,038.7 |
| 4 | УРЬДЧИЛГАА | 17,934.5 | 16,434.5 |
| 5 | БАРАА МАТЕРИАЛ | 220,553.3 | 289,956.3 |
| 6 | НӨӨЦИЙН БАРАА | 8,383.0 | 10,213.0 |
| 7 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 116,909.3 | 44,300.0 |
| 8 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,673,123.9 | 5,585,348.5 |
| 9 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,673,123.9 | 5,585,348.5 |
| 10 | Биет хөрөнгө | 3,416,582.2 | 4,327,015.5 |
| 11 | Биет бус хөрөнгө | 1,256,541.7 | 1,258,333.0 |
| 12 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 5,408,623.3 | 6,574,143.0 |
| 13 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 74,041.7 | 287,339.8 |
| 14 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 74,041.7 | 287,339.8 |
| 15 | Өглөг | 74,041.7 | 287,339.8 |
| 16 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,334,581.6 | 6,286,803.2 |
| 17 | Засгийн газрын хувь оролцоо | 5,334,581.6 | 6,286,803.2 |
| 18 | Засгийн газрын оруулсан капитал | 206,320.4 | 206,320.4 |
| 19 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 126,951.8 | 126,951.8 |
| 20 | Хуримтлагдсан үр дүн | 4,796,468.9 | 5,748,690.5 |
| 21 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 204,840.6 | 204,840.6 |
| 22 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 5,408,623.3 | 6,574,143.0 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 3,875,103.4 | 4,046,468.2 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 517,921.7 | 734,840.2 |
| 3 | Орлогын албан татвар | 434,799.0 | 406,522.2 |
| 4 | Хувь хүний орлогын албан татвар | 457,008.0 | 423,218.3 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (22,209.0) | (16,696.1) |
| 6 | Хөрөнгийн албан татвар | 74,687.3 | 81,706.9 |
| 7 | Бусад татвар, төлбөр, хураамж | 8,435.4 | 246,611.1 |
| 8 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,117,005.6 | 3,311,628.0 |
| 9 | Тусламжийн орлого | - | 1,172,170.0 |
| 10 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,240,176.1 | - |
| 11 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,182,786.6 | 2,249,614.8 |
| 12 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,182,786.6 | 2,249,614.8 |
| 13 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,087,521.8 | 2,194,132.2 |
| 14 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 704,425.7 | 699,573.6 |
| 15 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 88,007.6 | 89,807.9 |
| 16 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 474,098.9 | 595,161.7 |
| 17 | Хангамж, бараа материалын зардал | 310,239.2 | 75,109.3 |
| 18 | Эд хогшил, урсгал засварын зардал | 66,08760 | 71,303.7 |
| 19 | Томилолт, зочны зардал | 11,636.0 | 4,090.0 |
| 20 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,313.1 | 54,817.6 |
| 21 | Бараа үйлчилгээний бусад зардал | 395,714.3 | 604,268.3 |
| 22 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 95,264.8 | 55,482.6 |
| 23 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 1,692,316.8 | 1,796,853.5 |
| 24 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 766,505.6 | 825,833.9 |
| 25 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | (766,505.6) | (825,833.9) |
| 26 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 925,811.1 | 971,019.5 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,398,778.2 | 4,398,778.2 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 9,992.2 | 9,992.2 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,408,770.5 | 4,408,770.5 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | 925,811.1 | 925,811.1 |
| 5 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,334,581.6 | 5,334,581.6 |
| 6 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 5,334,581.6 | 5,334,581.6 |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (18,797.9) | (18,797.9) |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,315,783.7 | 5,315,783.7 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 971,019.5 | 971,019.5 |
| 10 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 6,286,803.2 | 6,286,803.2 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,821,349.5 | 2,632,632.8 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 517,921.7 | 734,840.2 |
| 3 | Орлогын албан татвар | 434,799.0 | 406,522.2 |
| 4 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (22,209.0) | (16,696.1) |
| 5 | Хөрөнгийн албан татвар | 74,687.3 | 81,706.9 |
| 6 | Бусад татвар, төлбөр, хураамж | 8,435.4 | 246,611.1 |
| 7 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 2,992.1 | 17,233.6 |
| 8 | Газрын төлбөр | 5,443.3 | 7,119.6 |
| 9 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | - | 222,257.9 |
| 10 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 63,251.7 | 1,897,792.6 |
| 11 | Нийтлэг татварын бус орлого | 63,251.7 | 112,311.0 |
| 12 | Тусламжийн орлого | - | 1,172,170.0 |
| 13 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 613,311.6 |
| 14 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,240,176.1 | - |
| 15 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,734,259.7 | 1,749,119.4 |
| 16 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,734,259.7 | 1,749,119.4 |
| 17 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,638,994.9 | 1,693,636.8 |
| 18 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 674,445.5 | 731,791.3 |
| 19 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 77,366.4 | 94,484.5 |
| 20 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 473,613.0 | 532,631.6 |
| 21 | Хангамж, бараа материалын зардал | 88,092.0 | 69,537.0 |
| 22 | Эд хогшил, урсгал засварын зардал | 69,862.0 | 73,163.7 |
| 23 | Томилолт, зочны зардал | 11,636.0 | 4,090.0 |
| 24 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 43,769.1 | 54,977.6 |
| 25 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,211.0 | 132,961.2 |
| 26 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 95,264.8 | 55,482.6 |

| | | | |
|---|---|---|---|
| 27 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 1,087,089.7 | 883,513.4 |
| 28 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 1,154,387.2 | 659,074.6 |
| 29 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,154,387.2 | 659,074.6 |
| 30 | Дотоод эх үүсвэрээр | 1,154,387.2 | 659,074.6 |
| 31 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (1,154,387.2) | (659,074.6) |
| 32 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (67,297.5) | 224,438.8 |
| 33 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 332,710.8 | 265,413.3 |
| 34 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 265,413.3 | 489,852.1 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,746,960.9 | 2,544,710.4 | 202,250.5 | 92.6 |
| 11 | Татварын орлого | 723,194.7 | 734,840.2 | (11,645.5) | 101.6 |
| 110 | Орлогын албан татвар | 366,545.2 | 406,522.2 | (39,977.0) | 110.9 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 383,241.2 | 423,218.3 | (39,977.1) | 110.4 |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 284,223.5 | 340,753.1 | (56,529.6) | 119.9 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 8,112.9 | 10,199.5 | (2,086.6) | 125.7 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 26,974.3 | 29,791.1 | (2,816.8) | 110.4 |
| 110008 | Шууд бус орлого | 63,930.5 | 42,474.6 | 21,455.9 | 66.4 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (16,696.0) | (16,696.0) | 0.0 | 100.0 |
| 110101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (16,696.0) | (16,696.0) | 0.0 | 100.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 111,618.0 | 81,706.9 | 29,911.1 | 73.2 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 2,723.5 | 11,345.1 | (8,621.6) | 416.6 |
| 113002 | Бууны албан татвар | 1,470.0 | 1,140.0 | 330.0 | 77.6 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 107,424.5 | 69,221.8 | 38,202.7 | 64.4 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 245,031.5 | 246,611.1 | (1,579.6) | 100.6 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 16,302.9 | 17,233.6 | (930.7) | 105.7 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 14,902.9 | 15,303.6 | (400.7) | 102.7 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 1,400.0 | 1,930.0 | (530.0) | 137.9 |
| 1181 | Газрын төлбөр | 5,400.0 | 7,119.6 | (1,719.6) | 131.8 |
| 118101 | Газрын төлбөр | 5,400.0 | 7,119.6 | (1,719.6) | 131.8 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 223,328.6 | 222,257.9 | 1,070.7 | 99.5 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 223,328.6 | 222,128.6 | 1,200.0 | 99.5 |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | - | 129.3 | (129.3) | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | Татварын бус орлого | 2,023,766.2 | 1,809,870.2 | 213,896.0 | 89.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 89,572.1 | 86,912.6 | 2,659.5 | 97.0 |
| 120003 | Торгуулийн орлого | 6,500.0 | 12,428.9 | (5,928.9) | 191.2 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 83,072.1 | 73,886.1 | 9,186.0 | 88.9 |
| 120009 | Бусад орлого | - | 597.6 | (597.6) | |
| 122 | Тусламжийн орлого | 1,314,687.4 | 1,109,646.0 | 205,041.4 | 84.4 |
| 122003 | Аймаг нийслэлээс авсан татаас | 1,109,646.0 | 1,109,646.0 | - | 100.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 205,041.4 | - | 205,041.4 | 0.0 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 619,506.7 | 613,311.6 | 6,195.1 | 99.0 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 619,506.7 | 613,311.6 | 6,195.1 | 99.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,746,960.9 | 2,345,721.7 | 401,239.2 | 85.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,756,682.7 | 1,686,647.0 | 70,035.7 | 96.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,698,732.7 | 1,631,164.4 | 67,568.3 | 96.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 731,837.6 | 731,791.3 | 46.3 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 701,113.5 | 494,811.2 | 206,302.3 | 70.6 |
| 210102 | Нэмэгдэл | 30,724.1 | 228,673.2 | (197,949.1) | 744.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 8,307.0 | (8,307.0) | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,282.8 | 94,484.5 | 798.3 | 99.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,148.5 | 66,554.1 | 1,594.4 | 97.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,100.8 | 7,059.9 | (959.1) | 115.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,505.6 | 3,588.5 | (82.9) | 102.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,505.6 | 3,427.9 | 77.7 | 97.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,022.3 | 13,854.0 | 168.3 | 98.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 556,789.2 | 532,631.6 | 24,157.6 | 95.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 79,592.6 | 53,873.8 | 25,718.8 | 67.7 |
| 210302 | Түлш, халаалт | 459,594.6 | 462,753.0 | (3,158.4) | 100.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 17,602.0 | 16,004.8 | 1,597.2 | 90.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 75,846.6 | 63,707.7 | 12,138.9 | 84.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,329.8 | 4,625.2 | 2,704.6 | 63.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,066.8 | 54,176.7 | 5,890.1 | 90.2 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500.0 | 1,158.5 | 341.5 | 77.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 900.0 | 298.5 | 601.5 | 33.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,050.0 | 3,448.8 | 2,601.3 | 57.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 73,740.0 | 71,848.7 | 1,891.3 | 97.4 |
| 210604 | Урсгал засвар | 73,740.0 | 71,848.7 | 1,891.3 | 97.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,600.0 | 4,090.0 | 1,510.0 | 73.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,600.0 | 4,090.0 | 1,510.0 | 73.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,477.0 | 5,137.6 | 4,339.4 | 54.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,405.0 | 1,531.5 | 2,873.5 | 34.8 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 72.0 | - | 72.0 | 0.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 200.0 | 125.4 | 74.6 | 62.7 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400.0 | - | 400.0 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,200.0 | 1,320.0 | 880.0 | 60.0 |
| 210807 | Газрын төлбөр | 2,200.0 | 2,160.7 | 39.3 | 98.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 150,159.5 | 127,473.1 | 22,686.4 | 84.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 148,159.5 | 126,195.1 | 21,964.4 | 85.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,000.0 | 1,278.0 | 722.0 | 63.9 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 57,950.0 | 55,482.6 | 2,467.4 | 95.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 57,950.0 | 55,482.6 | 2,467.4 | 95.7 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 53,100.0 | 52,735.6 | 364.4 | 99.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,850.0 | 2,747.0 | 2,103.0 | 56.6 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 900,731.2 | 659,074.6 | 241,656.6 | 73.2 |
| 223001 | Бусад хөрөнгө | 900,731.2 | 659,074.6 | 241,656.6 | 73.2 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 89,547.0 | - | 89,547.0 | 0.0 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 89,547.0 | - | 89,547.0 | 0.0 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | - | 198,988.8 | | |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | (198,988.8) | | |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | (198,988.8) | | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 246,614.1 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 445,602.8 | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 62,524.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 62,524.0 |
| 122 | Тусламжийн орлого | 62,524.0 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 62,524.0 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 62,524.0 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 60,324.0 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,200.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 62,472.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 62,472.4 |

| | | |
|---|---|---|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 62,472.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,829.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,279.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 555.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 995.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,315.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,315.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 49,840.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 49,840.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,488.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,488.1 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 51.6 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (51.6) |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (51.6) |

**Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

**3.1** Аудитаар 129.8 сая төгрөгийн бүртгэл тайлагналын 1 алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 63.4 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинөөс их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 96.2 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

### 3.1.1 Харьяа байгууллагууд

Эрдэнэ сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 1 ААТҮГ, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ХХС, БХНСС, ОНХС, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

### 3.1.2 Түүвэрт хамрагдсан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ХХС, БХНСС, ОНХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл, тайлагналыг 1,073.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 11 алдааг залруулж, 17.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 47.5 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл, тайлагналыг 308.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 2 алдааг залруулж, 3.5 сая төгрөгийн зөрчилд 2 акт, 25.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2.8 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 63.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөрчил арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлж байна.

### 3.3 Албан шаардлага

1. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 96.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 42.3 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 50.4 сая төгрөгийн зөрчилд холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт:</u>* Шууд бус орлого 21.5 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.3 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 38.2 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 1.2 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", "Сумын 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллах.

***2. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой***

*<u>Илрүүлэлт:</u>* Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас бэлэг дурсгал, шагналд 2.2 сая төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20 -ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>: Төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хууль тогтоомжоор хориглосон зардалд зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрдэнэ сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан | 1.0 | 129,763.5 | 1.0 | 129,763.5 | | | 1.0 | 129,763.5 | - | - | | - |
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | 2.0 | 308,833.2 | 2.0 | 308,833.2 | | | 2.0 | 308,833.2 | | | | |
| Эрдэнэ сумын ОНХС | 7.0 | 973,006.1 | 7.0 | 973,006.1 | | | 7.0 | 973,006.1 | - | - | | - |
| Эрдэнэ сумын ХХС | 4.0 | 100,452.1 | | | 4.0 | 100,452.1 | 4.0 | 100,452.1 | - | - | | - |
| **Дүн** | **14.0** | **1,512,054.9** | **10.0** | **1,411,602.8** | **4.0** | **100,452.1** | **14.0** | **1,512,054.9** | **-** | - | - | - |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Бүгд | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түүвэрт | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрдэнэ сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан | 1 | - | 1 | - | - | - | 3.0 | 63,434.6 | | | 1 | - | 2.0 | 63,434.6 | - | - | - | - |
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | 1 | - | 1 | - | - | - | 6.0 | 31,313.1 | 2.0 | 3,477.9 | 2.0 | 25,000.0 | 2.0 | 2,835.2 | - | - | - | - |
| Эрдэнэ сумын иргэдийн | | | | | | | - | - | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төлөөлөгчдийн Хурал | 1 | - | - | - | - | 1 | | | | | | | | | - | - | - | - |
| Эрдэнэ сумын ОНХС | 1 | - | - | - | - | 1 | 3.0 | 60,046.7 | | | 1.0 | 12,500.0 | 2.0 | 47,546.7 | - | - | - | - |
| Эрдэнэ сумын БХНСС | 1 | - | - | - | - | 1 | - | - | | | | | | | - | - | - | - |
| Эрдэнэ сумын ХХС | 1 | - | - | - | - | 1 | 1.0 | 4,850.0 | | | 1.0 | 4,850.0 | | | - | - | - | - |
| **Дүн** | **6** | **-** | **2** | | | **4** | **13.0** | **159,644.4** | **2.0** | **3,477.9** | **5.0** | **42,350.0** | **6.0** | **113,816.5** | - | - | - | - |